

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/91/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2023 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Отгонбаяр Утас: 89306788 Цахим хаяг: Otgonbayard@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.20 № 01/29
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА Ц.ЧИМЭДМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хангамжийн материал дансны үлдэгдэл өмнөх оноос 3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь Түнэл сумын ЗДТГ-ын шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой тохижилт үйлчилгээний материал худалдаж авснаас шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгохдоо 2,314.1 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 5 зорилт 128 арга хэмжээг төлөвлөж 89.5 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/А.ЭРДЭНЭБААТАР/

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,747,759.00	101,595,059.00
33	АВЛАГА	5,844,530.00	1,695,680.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,844,530.00	1,695,680.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,903,229.00	99,899,379.00
354	Хангамжийн материал	56,708,229.00	97,144,379.00
35420	Аж ахуйн материал	12,407,880.00	52,844,030.00
35470	Бусад хангамжийн материал	44,300,349.00	44,300,349.00
35600	Мал амьтад	2,195,000.00	2,755,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,677,858,712.43	2,701,061,981.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,677,858,712.43	2,701,061,981.88
392	Биет хөрөнгө	2,665,305,479.29	2,689,369,248.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,695,499,783.80	2,709,699,783.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-232,589,577.54	-296,367,964.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	200,594,935.00	68,470,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-144,412,097.62	-42,463,327.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,024,021.00	162,970,854.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-46,754,450.90	-45,543,732.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,097,396.00	68,811,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,549,906.23	-13,543,358.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	96,909,212.00	96,909,212.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,513,836.22	-19,574,517.02
393	Биет бус хөрөнгө	12,553,233.14	11,692,733.06
39301	Програм хангамж	3,442,000.00	3,442,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-662,500.00	-1,523,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	9,773,733.14	9,773,733.14
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,742,606,471.43	2,802,657,040.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,742,606,471.43	2,802,657,040.88
51	Засгийн газрын хувь оролцоо	2,742,606,471.43	2,802,657,040.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,769,617,618.89	2,769,617,618.89
51101	Өмч: - төрийн	2,769,617,618.89	2,769,617,618.89
512	Хуримтлагдсан үр дүн	-218,273,520.39	-158,222,950.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-218,273,520.39	-218,273,520.39
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	60,050,569.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,262,372.93	191,262,372.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,742,606,471.43	2,802,657,040.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,535,440.80	753,596,799.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,765,140.80	168,634,499.00
120	Нийтлэг татварын бус орлого	228,765,140.80	168,634,499.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	228,765,140.80	168,634,499.00

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,930,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,770,300.00	584,962,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,774,500.00	31,725,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,950,000.00	16,095,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,635,500.00	11,171,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,189,000.00	4,459,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	482,995,800.00	553,236,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	482,995,800.00	553,236,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	553,700,380.84	655,997,429.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,700,380.84	655,997,429.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,106,672.84	617,372,019.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,870,423.00	287,661,900.14
210101	Үндсэн цалин	211,591,213.00	218,866,022.14
210102	Нэмэгдэл	63,279,210.00	50,565,561.00
210104	Урамшуулал	00.00	18,230,317.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,398,106.00	35,937,192.00
210201	Тэтгэврийн даатгал	27,761,853.00	24,484,507.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,672,225.00	2,854,893.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,134,786.00	2,282,104.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,885.00	570,526.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,299,357.00	5,745,162.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,280,626.00	29,450,099.00
210301	Гэрэл, цахилгаан	2,711,170.00	4,150,099.00
210302	Түлш, халаалт	18,344,456.00	25,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	225,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,864,250.00	42,983,375.00
210401	Бичиг хэрэг	3,966,700.00	10,869,800.00
210402	Тээвэр, цатахуун	15,550,060.00	20,722,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,096,700.00	3,330,000.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	298,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,447,290.00	221,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, гэхуйн эд зүйлс	2,503,500.00	7,540,315.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,410,300.00	13,160,880.00
210602	Тавилга	00.00	1,164,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	8,610,300.00	11,496,480.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,377,257.00	49,669,444.00

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,891,240.00	48,055,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,900.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	289,272.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	699,500.00
210807	Газрын төлбөр	577,617.00	92,022.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,905,710.84	154,509,129.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,752,400.00	31,640,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	103,153,310.84	122,869,129.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,593,708.00	38,625,409.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,538,355.00	25,862,084.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	460,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,329,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,641,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,436,855.00	8,532,484.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,055,353.00	12,763,325.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,055,353.00	12,763,325.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	167,835,059.96	97,599,369.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,912,410.90	37,548,800.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,912,410.90	37,548,800.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,912,410.90	-37,548,800.39
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	164,922,649.06	60,050,569.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	498,842,920.00	590,806,830.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,930,900.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,930,900.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,930,900.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,930,900.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	496,912,020.00	590,806,830.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,916,220.00	37,570,430.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,506,400.00	18,795,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,635,500.00	11,171,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,774,320.00	7,604,030.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	482,995,800.00	553,236,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	482,995,800.00	553,236,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	475,750,220.00	540,762,630.00

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,750,220.00	540,762,630.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,311,982.00	500,441,540.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,870,460.00	290,292,155.14
210101	Үндсэн цалин	211,591,250.00	221,496,277.14
210102	Нэмэгдэл	63,279,210.00	50,565,561.00
210104	Урамшуулал	00.00	18,230,317.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,398,069.00	33,306,937.00
210201	Тэтгэврийн даатгал	27,669,669.00	22,738,336.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,682,100.00	2,642,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,145,700.00	2,113,701.00
210204	Ажилгүйдлийн даатгал	536,400.00	528,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,364,200.00	5,284,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,280,626.00	29,450,099.00
210301	Гэрэл, цахилгаан	2,711,170.00	4,150,099.00
210302	Түлш, халаалт	18,344,456.00	25,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	225,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,142,450.00	39,543,025.00
210401	Бичиг хэрэг	3,966,700.00	10,869,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,550,060.00	20,722,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,096,700.00	3,330,000.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	298,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,447,290.00	221,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,781,700.00	4,099,965.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,798,900.00	13,645,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	366,600.00	310,400.00
210602	Тавилга	13,022,000.00	1,339,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	8,610,300.00	11,496,480.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,489,077.00	59,003,444.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,003,060.00	57,389,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,900.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	289,272.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	699,500.00
210807	Газрын төлбөр	577,617.00	92,022.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,332,400.00	31,200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,332,400.00	31,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,438,238.00	40,321,089.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,538,355.00	25,862,084.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	460,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,329,600.00

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,641,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,436,855.00	8,532,484.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,899,883.00	14,459,005.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,899,883.00	14,459,005.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,092,700.00	50,044,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,092,700.00	50,044,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,092,700.00	50,044,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,092,700.00	50,044,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,092,700.00	50,044,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-23,092,700.00	-50,044,200.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,769,617,618.89	191,262,372.93	-218,273,520.39	2,742,606,471.43
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,769,617,618.89	191,262,372.93	-218,273,520.39	2,742,606,471.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,769,617,618.89	191,262,372.93	-218,273,520.39	2,742,606,471.43

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	60,050,569.45	60,050,569.45
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,769,617,618.89	191,262,372.93	-158,222,950.94	2,802,657,040.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	550,913,300.0	540,473,074.1	10,440,225.9	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,913,300.0	540,473,074.1	10,440,225.9	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526,723,700.0	516,290,990.1	10,432,709.9	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,159,000.0	290,292,155.1	6,866,844.9	97.7
210101	Үндсэн цалин	227,197,800.0	221,496,277.1	5,701,522.9	97.5
210102	Нэмэгдэл	51,471,100.0	50,565,561.0	905,539.0	98.2
210104	Урамшуулал	18,490,100.0	18,230,317.0	259,783.0	98.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,352,500.0	33,306,937.0	45,563.0	99.9
210201	Тэтгэврийн даатгал	22,783,900.0	22,738,336.0	45,564.0	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,642,100.0	2,642,100.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,113,700.0	2,113,701.0	-01.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	528,400.0	528,400.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,284,400.0	5,284,400.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,800,000.0	29,450,099.0	349,901.0	98.8
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.0	4,150,099.0	349,901.0	92.2
210302	Түлш, халаалт	25,000,000.0	25,000,000.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	300,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,839,200.0	33,808,025.0	31,175.0	99.9
210401	Бичиг хэрэг	10,240,800.0	10,240,800.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,648,400.0	15,646,430.0	1,970.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.0	3,300,000.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	300,000.0	298,980.0	1,020.0	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.0	221,850.0	28,150.0	88.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100,000.0	4,099,965.0	35.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,645,300.0	45,550,480.0	94,820.0	99.8

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.0	8,000,000.0	00.0	100.0
210602	Тавилга	25,590,000.0	25,554,000.0	36,000.0	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.0	500,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	11,555,300.0	11,496,480.0	58,820.0	99.5
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.0	4,000,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	4,000,000.0	4,000,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,727,700.0	48,683,294.0	3,044,406.0	94.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,377,700.0	47,069,500.0	2,308,200.0	95.3
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	500,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	289,272.0	10,728.0	96.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.0	33,000.0	117,000.0	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.0	699,500.0	500.0	99.9
210807	Газрын төлбөр	700,000.0	92,022.0	607,978.0	13.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,200,000.0	31,200,000.0	00.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,200,000.0	31,200,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,189,600.0	24,182,084.0	7,516.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,189,600.0	24,182,084.0	7,516.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,329,600.0	17,329,600.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,860,000.0	6,852,484.0	7,516.0	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	550,913,300.0	540,473,074.1	10,440,225.9	98.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,913,300.0	540,473,074.1	10,440,225.9	98.1
132001	Орон нутгийн төсвөөс	550,913,300.0	540,473,074.1	10,440,225.9	98.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТӨӨ	26.00	26.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,874,750.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,194,750.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,269,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	5,735,000.00	
210401	Бичиг хэрэг	629,000.00	

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	5,076,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,759,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,759,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,680,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,680,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,570,430.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,570,430.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,795,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,171,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,604,030.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын Тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Түнэл сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Түнэл сумын ЗДТГ нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Санхүүгийн үндсэн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж, үр дүнтэй төсвийн төлөвлөлт хийнэ.
2. Нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
3. Захиргааны үйлчилгээг чанартай хүргэнэ.
4. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.
5. Бүтээн байгуулалт, бүтээлч ажлыг зохион байгуулан шинэ санаачилгыг дэмжин ажиллана.
6. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хуулийн хүрээнд хангана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:
Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Түнэл сумын ЗДТГ-ын даргын тушаалаар 3 орон тоотой дотоод хяналтын баг томилон ажиллуулж байна. 2022 оны 12 дугаар сард аймгийн Санхүү хяналт аудитын албанаас Түнэл сумын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,050.5 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5,844.5	1,695.7	-4,148.8
Бараа материал	58,903.2	99,899.4	40,996.2
Үндсэн хөрөнгө	2,677,858.7	2,701,061.9	23,203.2
Нийт хөрөнгө	2,742,606.5	2,802,657.0	60,050.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,769,617.6	2,802,657.0	33,039.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,742,606.5	2,802,657.0	60,050.5

Дээрх хүснэгтээс харахад

- Авлага данс өмнөх оноос 4,148.8 мянган төгрөгөөр буурсан нь, нэмэлт санхүүжилтийн орлого 1,695.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, авлага үүсгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 40,996.2 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газрын шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой байрны тохижилтод зориулж хангамжийн материал худалдан авсан байна.
- үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 23,203.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар үнэ төлбөргүй 67,279.7 мянган төгрөгийн хөрөнгө, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 54,437.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.
- Өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн өмнөх оноос 60,050.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 434,357.7 мянган төгрөг, нийт зарлагыг 434,357.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх дүнг 58,277.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 492,635.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 58,787.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 195,843.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 355,070.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,473.1 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	344.618.5	341.996.4	2622.1	91.9%
2		80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	68.288.5	61.756.1	6532,4	90.4%
3		80112-Нийтлэг үйлчилгээ	42.739.0	37.222.9	5.516.0	87.1%
4		80305-Биеийн тамир тэмцээн уралдааны зардал	0.0	0.0	0	0%
5		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	6860.0	6.432.5	427.5	93.8%
6		80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	17.329.6	17.329.	0	100%
7		81102-Орсон нутгийн нөөц хөрөнгө	23.200.0	23.200.0	0	100%
8	70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	82801-Улсын их баяр наадам	8.000.0	8.000.0	0	100%
9		80918-Бусад	0.0	0.0	0	0%
10		71413-Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	39.877.7	37.569.5	2308,2
Нийт дүн			550.913.3	540.473.1	10.440.2	98.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 37,570.4 мянган төгрөг хүлээн авсан байна. Үүнд:

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

- Аймгийн Засаг даргын А/154 тоот захирамжийн дагуу шүлхий өвчний вакцины зардал 4,916.2 мянган төгрөг,
- Аймгийн статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 3,955.2 мянган төгрөг
- Сумын түүхт 70-н жилийн ойн баярын арга хэмжээний зардал 26,374.3 мянган төгрөг,
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд цахим тендерийн үнэ 629.0 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн данснаас 35,874.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 494,161.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,883.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ЗДТГ-ын А/54 тоот тушаалын дагуу шинэ байрны нээлтийн бэлэг /мөнгөн аяганы үнэ/ Анар принт ХХК-д 850.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5¹ дахь заалтыг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

¹ Төсвийн болон байгууллагын хэрэгнөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
 - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
 - Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
1. Нийт 42 мэдээлэл байршуулахаас 42 мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлсэн байна.
 2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 544,235.8 мянган төгрөгийн 16 гүйлгээ, зарлагын 64,419.7 мянган төгрөгийн 7 гүйлгээг хугацаанд нь мэдээлсэн. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 49,873.4 мянган төгрөгийн 8 шийдвэрийг хугацаанд нь мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой:

- Түнэл сумын ЗДТГ-ын дарга Ц.Чимэдмаад 2022 онд үр дүнгийн урамшууллыг 50 хувиар олгохоор сумын Засаг дарга шийдвэрлэсэн байхад үндсэн цалингийн 100 хувиар бодож 522.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.
Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2² дахь заалт, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн урамшуулал олгох Б/24 дугаар тушаалд заасан хувь хэмжээтэй тус тус нийцэхгүй байна.

² "Төрийн албан хаагчид улирлын ажлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна"

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

- Түнэл сумын ЗДТГ-ын ажилчдад 3,4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг олгоходоо 12 ажилтанд 1,791.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь заалт, Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн урамшуулал олгох Б/21 дугаар тушаалд заасан хувь хэмжээтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

1. Төсвийн зарцуулалттай холбоотой:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Түнэл-Илч ХХК-д 4,251.8 мянган төгрөгийн халаалтын зардал, Түнэл хамтын хүч хоршоонд 405.4 мянган төгрөг, Хатан Түнэл ХХК-д 1,064.4 мянган төгрөгийн байрны нээлтийн хоолны үнэ шилжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 65,800.0 мянган төгрөгийн зөрчилд, 1 зөвлөмж, Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 29,092.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлага болон зөвлөмжийн 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	29,092.7	1	29,092.7	100%
Зөвлөмж	1	65,800.0	1	65,800.0	100%
Нийт дүн	1	94,892.7	1	94,892.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

³ Төсвийг зориулалтын дагуу зарцуулах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,885.7 мянган төгрөгийн 3 зөрчил⁴ илэрснээс, 3,164.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,721.6 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас ЗДТГ-ын А/54 тоот тушаалын дагуу шинэ байрны нээлтийн бэлэг /мөнгөн аяганы үнэ/ Анарпринт ХХК-д 350.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5⁵ дахь заалтыг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт: Түнэл сумын ЗДТГ-ын дарга Ц.Чимэдмаад 2022 онд үр дүнгийн урамшууллыг 50 хувиар олгохоор сумын Засаг дарга шийдвэрлэсэн байхад үндсэн цалингийн 100 хувиар бодож 522.8 мянган төгрөгийг илүү олгосон, Түнэл сумын ЗДТГ-ын ажилчдад 3,4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо 12 ажилтанд 1,791.3 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2⁶ дахь заалт, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн урамшуулал олгох Б/24 дугаар тушаалд заасан хувь хэмжээтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой:

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Түнэл-Илч ХХК-д 4,251.8 мянган төгрөгийн халаалтын зардал, Түнэл хамтын хүч хоршоонд 405.4 мянган төгрөг, Хатан Түнэл ХХК-д 1,064.4 мянган төгрөгийн байрны нээлтийн хоолны үнэ шилжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁵ Төсвийн болон байгууллагын хэрэгнөөр бэлэг дурсгалын зүйл худалд ан авах

⁶ "Төрийн албан хаагчид улирлын ажлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна"

⁷ Төсвийг зориулалтын дагуу зарцуулах

**Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн	1	850.0	1	850.0	-	-	-	-
Үр дүнгийн урамшууллыг илүү тооцож олгосон	1	2,314.1	1	2,314.1	-	-	-	-
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	5,721.3	-	-	1	5,721.3	-	-
Дүн	3	8,885.4	2	3,164.1	1	5,721.3	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНИЯМ ОГНОО:

Д.ОТГОНБАЯР ОГНОО: